

ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИД
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

Захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Гүйцэтгэсэн: Н.Норовсамбуу /МУИС, Хууль зүйн сургуулийн багш/

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.¹

Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.²

Түүнчлэн, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-т нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн болон давж заалдах шатны шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх 12 дугаар бүлгийн ач холбогдол бүхий зарим зохицуулалт болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван наймдугаар бүлэгт заасан Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэх шаардлага бий болсон. Үүнээс төлөвлөх үе шатанд дараах асуудлыг тодруулна. Үүнд:

- 1/Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- 2/Үнэлгээ хийх хүрээг сонгож тогтоох;
- 3/Шалгуур үзүүлэлтийг сонго тогтоох;
- 4/Харьцуулах хэлбэрийг сонгох;
- 5/Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- 6/Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1.Үнэлгээ хийх шалтгаан, хүрээг тодорхойлох

1/Гэр бүл цуцлуулах нэхэмжлэлийг шийдвэрлэхэд шүүхээс эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авах зохицуулалтын тухайд:

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4 /Харин Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно./-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721217671>

маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ.” гэж заасан.

Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.3-т заасан шүүхээс гадуур **урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулахаас татгалзах үндэслэл болохгүй.**” гэж заасан.

Үүнээс гадна Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсэгт “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.” гэж, 132.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 132.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй.” гэж заасан нь гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсоноос бусад тохиолдолд заавал шүүхийн шатанд, гэрлэлт цуцлуулахгүй буюу бодит утгаар эвлэрэхэд чиглэсэн ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэхэд хүргэсэн байна.

Мөн үүнээс өмнө Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан зохицуулалт нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулж, амжилтгүй болсон ч шүүхэд хандаад дахин эвлэрүүлэн зуучлалаар орох давхар эвлэрүүлэн зуучлалаар орох шаардлагыг харуулж байна.

Тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1.7 дахь заалтад “Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа заах арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно” гэж, мөн хуулийн 132 дугаар зүйлийн 132.5 дахь хэсэгт “Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана.” гэж зааснаас харахад **заавал шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд орох, ингэж орох зорилго нь цуцлуулах нэхэмжлэлтэй гэрлэгчдийг гэрлэлтээ цуцлуулахгүй байх буюу бодит утгаараа эвлэрүүлэхэд чиглэж байна.**

Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ.” гэж, мөн зүйлийн 14.2 дахь хэсэгт “Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна. Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.” гэж, 14.3 дахь хэсэгт “Гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусмагц шүүх гэрлэлтийг цуцална.” гэж шүүхэд гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахад заавал бодит утгаараа эвлэрч, гэрлэлтээ цуцлуулахаа болих шийдвэр гаргахад чиглэсэн шүүх

дэх эвлэрүүлэн зуучлалаар орох 3 хүртэл сарын хугацаа өгөхөөр, энэ хугацаанд эвлэрээгүй бол шүүх гэрлэлтийг цуцлахаар байна.

Ингэснээр гэрлэлт цуцлалтын тохиролцоог талууд эвлэрүүлэн зуучлалын үе шатанд хийлгүйгээр эвлэрүүлэн зуучлалын хугацаа өнгөрөх, шүүх өөрөө үүний дараа шууд цуцлан хүүхдийн болон эд хөрөнгийн асуудлаар шийдвэр гаргахаар байна.

Энэ нь гэр бүл нь аливаа нийгмийг бүрдүүлэгч суурь нэгж, үнэт зүйл болохын хувьд төрөөс гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн тасралтгүй хөгжил, хүмүүжлийг хадгалах бодлогыг баримтлан гэрлэлтийг шүүхээс аль болох шууд цуцлахгүйгээр эвлэрүүлэх арга замыг эрэлхийлжээ.³

Гэтэл 2018 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд гэр бүлийн эрх зүйн маргааны 2995 өргөдөл ирсэн бөгөөд үүнээс 412 өргөдөл буюу 13.6 хувьд нь амжилттай эвлэрсэн, 2019 онд гэр бүлийн эрх зүйн маргааны 3020 өргөдөл ирсэнээс 377 өргөдөл буюу 12.4 хувьд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай явагдсан байна.⁴ Эндээс үзэхэд, **77 хувьд нь гэр бүлийн эрх зүйн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй явагддаг** байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1.7 дахь заалтад шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх 3 хүртэл сарын хугацаа заах урьдчилсан арга хэмжээ авдаг. Ингэхээр шүүхээс гадуур эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу талууд хүсвэл авах, амжилтгүй болвол шүүхэд хандах, шүүхэд хандахад нь дахин урьдчилсан арга хэмжээ авч, эвлэрэх хугацаа зааж, шүүх дэх, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар орохыг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу шаарддаг.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1 /Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна. /-д заасан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Тэгэхээр шүүхэд хандахаас өмнө Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан шүүхийн бус журмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа буюу тухайн маргаанд зуучлуулахаар талуудын сонгосон буюу зөвшөөрсөн, маргааны талаар шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий мэргэшсэн этгээдээр шийдвэрлүүлэх ажиллагаа нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлал атлаа шүүх иргэний хэрэг үүсгэснээс хойш эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авах хүрээнд мөн

³ Т.Лхагважаргал, Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2022.

⁴ Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг ТББ, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, 2020, 59 дэх тал.

шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэхээр байгаад байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.5 дахь хэсэгт “Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана.” гэж заасан нь шүүх шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлал, үүнээс гадна иргэний хэрэг үүсгэснээс хойш эвлэрүүлэх бүх арга хэмжээ авах байдлаар гэрлэлтийг цуцлуулах асуудлыг хойшлуулдаг байна.

Гэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт “Шүүгч энэ хуулийн 129 дүгээр зүйлд заасан гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ /үүнд эвлэрэх хугацаа заах орно/-г зохигчийн хүсэлтээр өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.” гэж заасан нь зохигчийн хүсэлтээр эвлэрэх хугацаа зааснаа өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болохоор тусгажээ.

Мөн Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.” гэж зааснаас харахад эвлэрүүлэн зуучлалаар цуцлуулахтай холбоотой хүүхэд, хөрөнгийн асуудлаа шийдвэрлэж болох байдлаар тусгажээ.

Иймд шүүх иргэний хэрэг үүсгэснээс хойш эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авах зохицуулалт нь зорилгодоо хүрсэн эсэхэд дүгнэлт хийх, тухайн зохицуулалт нь зорилгодоо хүрсэн эсэх, хэрэв хүрээгүй бол асуудлын шалтгаан юу болохыг тодруулах замаар үнэлгээ өгөхөд энэхүү судалгаа чиглэх болно.

2/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлд заасан зарим гэр бүлийн холбогдолтой асуудлыг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг тухайд:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1-д онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх зарим асуудлыг тусгасан. Үүнд мөн хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.1 дэх заалтад эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох /Үүнд хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох зэрэг орно /, 133.1.4 дэх заалтад хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, мөн 133.1.5 дахь заалтад асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох зэрэг гэр бүлийн холбогдолтой асуудлыг багтаасан.

Харин хуулийн 134 дүгээр зүйлийн 134.1 дэх хэсэгт “Онцгой ажиллагааны журмаар шүүх хянан шийдвэрлэх хэргийг бусад хууль болон энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу шийдвэрлэнэ.” гэж заасан ч энэ бүлэгт өөрөөр заагаагүй тул ерөнхий журмын дагуу шийддэг.

Иймд эдгээр онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэрэг маргааны журам гэгдэх зохицуулалтад дүн шинжилгээ хийж, зорилгодоо хүрсэн байдалд үнэлгээ өгнө.

З/ИХШХШТХ-ийн зарчим ба гэр бүлийн холбогдолтой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд уг зарчим үйлчилж буй байдалд хамаарах зохицуулалтуудын тухайд:

Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1-д хуулийн зорилтыг тодорхойлсон байх бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.1-д заасан бол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөхөөр хуулийн 2.2-т заасан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог бол диспозитив болон мэтгэлцэх зарчмууд мөн. Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь "...диспозитив буюу зохигчдын санаачилга, хүсэлтийн үндсэн дээр явуулах болон мэтгэлцэх зарчимд үндэслэдэг явдал юм."⁵ Энэ нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, зохигч эвлэрэх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх зэргээр илэрч хэрэгжихээс гадна диспозитив зарчмыг шууд үгчлэн хуульчлаагүйгээс ойлголтын янз бүрийн асуудал үүсгэж болох бөгөөд мэтгэлцэх зарчмыг ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд зохицуулсан.⁶

ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр, уг зарчим бүх шатанд хэрэгжихээр заасан.

Мөн хэсэгт зохигч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нь хэргийн үйл баримт, гэм буруу байгаа эсэхийг нотлох буюу үгүйсгэх замаар мэтгэлцэх, гагцхүү бодит байдалд нийцсэн тайлбар өгөх, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт гаргах үүрэгтэй.

Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлагын талаарх тайлбарыг гагцхүү зохигч талууд гаргана. Хуулийн 133 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэрэгт энэ зүйл хамаарахгүй.

Үүнд, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох /садан, төрлийн холбоо, бусдын асрамжинд байгаа эсэх, төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, хүүхдээ тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх/, хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж

⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, 289 дүгээр тал.

⁶ Мөн тэнд.

зарлах, сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох зэрэг асуудалд мэтгэлцэх зарчим хэрэгждэггүй болно.

Харин захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчмаас гадна шүүх нотлох зарчим үйлчлэх бөгөөд шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй байна.⁷

Үүгээрээ нийтийн болон хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарчим ялгаатай хэдий ч гэр бүлийн холбогдолтой хэрэгт диспозитив зарчмаас гадна шүүхээс хянан шалгах, нотлох баримт цуглуулах үүрэг бусад улсуудад байгааг харгалзан одоогийн иргэний процессын хууль дахь ерөнхий зарчим гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд тохиромжтой эсэх, зорилгодоо хүрсэн эсэхийг шалгана.

Мөн бусад шүүх хуралдааныг нээлттэй явуулах, хугацааны талаарх ердийн журам гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд хамаарч байгаа зохицуулалтуудын практикт нийцсэн байдалд дүн шинжилгээ хийнэ.

4/Өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхэд дүгнэлт өгнө.

1.2.Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд сонгож авсан асуудлын онцлогоос хамааран зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.2.1.Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1-д хуулийн зорилтыг тодорхойлсон байх бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.1-д заасан бол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөхөөр хуулийн 2.2-т заасан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог бол диспозитив болон мэтгэлцэх зарчмууд мөн. Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь "...диспозитив буюу зохигчдын санаачилга, хүсэлтийн үндсэн

⁷ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл.

дээр явуулах болон мэтгэлцэх зарчимд үндэслэдэг явдал юм.”⁸ Энэ нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, зохигч эвлэрэх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх зэргээр илэрч хэрэгжихээс гадна дизпозитив зарчмыг шууд үгчлэн хуульчлаагүйгээс ойлголтын янз бүрийн асуудал үүсгэж болох бөгөөд мэтгэлцэх зарчмыг ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд зохицуулсан.⁹

Харин захиргааны хэрэг маргааны хувьд нэг талд нь захиргааны байгууллага, нөгөө талд тэдний хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирсон иргэн, байгууллага байдаг тул дээд шатны албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хуулиар заавал байхаар тогтоосон бөгөөд үүнийг биелүүлээгүй бол шүүхэд гомдол, нэхэмжлэл авахаас татгалзах үндэслэл болдог.¹⁰

Харин иргэний хэрэг маргааны тухайд ийм урьдчилан шийдвэрлэх ажиллагааг тавьдаггүй буюу талууд хүсвэл шүүхийн бус журмаар маргаанаа шийдвэрлүүлэх, үгүй бол шүүхэд хандах эрх нь нээлттэй байдгаар диспозитив зарчим илэрнэ.

Тэгвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд 2 давхар эвлэрүүлэн зуучлалаар орох буюу эхнийх нь амжилтгүй болвол шүүхэд хэрэг үүсгэснээс хойш дахин эвлэрүүлэн зуучлалаар орох шаардлага тавьсан хуулийн зохицуулалт, мөн эвлэрүүлэх ажиллагааны зорилго нь юу байсан, зорилгодоо хүрч байгаа эсэхийг тодорхойлох үүднээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг сонгов. Сонгосон хэсгүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгодоо хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсэг	132.1.“Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.”
2	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэг	132.2.Энэ хуулийн 132.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй.
3	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 130 дугаар	130.1.Шүүгч энэ хуулийн 129 дүгээр зүйлд заасан гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ /үүнд эвлэрэх хугацаа заах орно/-г зохигчийн хүсэлтээр өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

⁸ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, 289 дүгээр тал.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53 дугаар зүйл.

	зүйлийн 130.1 дэх хэсэг	
4.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугар зүйлийн 132.4 дэх хэсэг	132.4.Харин Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.

Хүснэгт 2. Зорилгодоо хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1	133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэг	133.1.Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх маргаан: Үүнд мөн хуулийн 133.1.1 дэх заалтад эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох /Үүнд хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох зэрэг орно / 133.1.4 дэх заалтад хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, 133.1.5 дахь заалтад асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох.
2	134 дүгээр зүйлийн 134.1 дэх хэсэг	134.1.Онцгой ажиллагааны журмаар шүүх хянан шийдвэрлэх хэргийг бусад хууль болон энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу шийдвэрлэнэ.

Хүснэгт 3. Зорилгод хүрсэн эсэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	3.2 дугаар зүйлийн 2.Хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

ИХШХШТХ-ийн зарчим ба гэр бүлийн холбогдолтой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд уг зарчим үйлчилж буй байдалд хамаарах

зохицуулалтуудын тухайд мөн зорилгод хүрсэн эсэхэд үнэлэлт өгнө. Учир нь гэр бүлийн холбогдолтой хэрэг нь иргэний хэрэг бөгөөд ИХШХШТХ-ийн Арван хоёрдугаар бүлгээр зохицуулсан ч энд хугацаа, нотлох үүрэг зэрэг гэр бүлийн холбогдолтой маргаанд онцлог зохицуулалт хийгдээгүй байгаа нь гэр бүлийн холбогдолтой хэргийг цогцоор нь бүрэн зөв шийдвэрлэх зорилгодоо хүрч байгааг тодруулна. Иймээс ердийн журмаар, ИХШХШТХ-д заасан зарчмыг хуульчилсан зохицуулалтыг сонгов.

1.3.Шалгуур үзүүлэлтийг томъёолох, харьцуулах хэлбэрийг сонгох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зүйл, хэсэг, заалтад тохируулан асуулт дэвшүүлж байна.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан тохиолдолд заавал эвлэрүүлэн зуучлалаар оруулж бодит утгаар нь цуцлуулуулахгүй байлгах, бодитоор эвлэрүүлэх нь зорилгодоо хүрч чадсан эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох буюу хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох зэрэг, түүнчлэн хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох зэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх нь зорилгодоо хүрсэн эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. ИХШХШТХ-ийн зарчим гэр бүлийн холбогдолтой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчилж байгаа нь зорилгодоо хүрсэн эсэх?

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэх талаарх зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан нөхцөл, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан доор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонголоо. Үүнд:

1.Байх ёстой болон одоо байгаа онцгой ажиллагааны журмаар гэр бүлийн холбогдолтой хэргийг шийдвэрлэхээр хуульчилсан нь практикт ямар асуудал үүсгэж буйг судлан тогтооно.

2.Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс өмнө хууль тогтоомж хүчин төгөлдөр болсноос хойш онцгой ажиллагааны журмаар гэр бүлийн хэргийг хэр амжилттай шийдвэрлэж байсан хэрэгжилтэд дүн шинжилгээ хийнэ.

3.Тохиолдол судлах- онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж байгаа гэр бүлийн хэргийг хэрхэн шийдвэрлэдэг гадаад улсын туршлага, онцлог, манай улсаас

ялгаатай сэтгэлгээ зэргийг харьцуулах замаар Монгол Улсын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийг зорьж байна.

1.4. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн, практикт нийцэж буй байдлыг тодруулах зорилгоор шүүхийн практик, тухайн сэдвээр гаргасан мэргэжлийн ном, товхитол, гарын авлага, өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийг эх сурвалж болгон ашиглав.

ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.

Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан тохиолдолд заавал эвлэрүүлэн зуучлалаар оруулж бодит утгаар нь цуцлуулуулахгүй байлгах, эвлэрүүлэх нь зорилгодоо хүрч чадсан эсэх?

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар эвлэрүүлэн зуучлалыг дараах 4 зарчимд үндэслэн явуулна. Үүнд:

1. Талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих;
2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах;
3. Эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх;
4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох зэрэг болно.

Ийнхүү талууд сайн дурын үндсэн дээр эвлэрүүлэн зуучлалыг явуулах зарчим тусгалаа олсон ч гэсэн гэр бүлийн холбогдолтой маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өөр тав дахь **албадан эвлэрүүлэх зарчим үйлчлэх** Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заажээ. Тодруулбал, ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж зааснаар гэр бүл цуцлах маргаанд уг ажиллагаа хийгдэхгүйгээр шүүхэд иргэний хэрэг үүсгэх боломжгүй болжээ. Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “... гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд **эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ.**” гэж хуульчилсан.¹¹

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсэгт “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.” гэж, мөн

¹¹ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ), 264 дүгээр тал.

зүйлийн 132.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 132.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ.

Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй.” гэж заасан нь сайн дурын бус “албадан эвлэрүүлэх зарчим” үйлчилж байгааг харуулж байна.

Өөрөөр хэлбэл, талууд эвлэрэх боломжгүй гэж үзвэл шүүх иргэний хэрэг үүсгэсний дараа тус хуулийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан дахин хэрэгжүүлнэ.

Ийнхүү гэрлэлт цуцлах маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хоёр удаа явуулах шаардлагатай.¹²

Улсын дээд шүүхийн 2010 оны ИХШХШ ажиллагаан дахь зохигчдыг эвлэрүүлэх шүүгчийн ажиллагааны тухай 02 зөвлөмжид дараах зүйлийг тайлбарлаж, анхааруулсан байдаг. Үүнд:

- Талууд **бусдын албадлагагүйгээр** өөрийн ухамсарт ажиллагааны үр дүнд маргааныг зохицуулах нь тэдний сэтгэл санаа, эд хөрөнгө, цаг завьг барахгүйгээс гадна эрх зүйн ухамсрыг нь дээшлүүлэх үндэс суурь болохын зэрэгцээ дахин энэ төрлийн харилцаанд алдаа зөрчилгүй оролцох боломжийг бүрдүүлдэг учир шүүгч талуудад маргааны шалтгаан, нөхцөлийг тайлбарлах, алдаа зөрчлийг нь ойлгуулах ажиллагаа явуулсны эцэст тэдгээрт өөрсдөө тохиролцох боломжийг нь олгох учиртай. Эвлэрэх болон муудалцах үйлдлийг хүн зөвхөн өөрийн хүсэл зоригоор хийдэг учир шүүх эвлэрэх хүсэл зоригийг нь өдөөх л ажиллагаа явуулахаас бус ямар нэгэн хэлбэрийн дарамт үзүүлэхгүй гэдгийг онцгой анхаарах учиртай гэжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шинэчилсэн мэдээллээр, 2021 онд 45,444 иргэний хэрэг шийдвэрлэснээс Гэр бүлийн тухай хуулиар 4690 буюу нийт иргэний хэргийн 10.3 хувийг, 2022 онд нийт шийдвэрлэгдсэн 57,633 иргэний хэргийн 6263 буюу 10.8 хувийг, 2023 онд шийдвэрлэгдсэн нийт 63,407 иргэний хэргийн 5913 буюу 9.3 хувийг Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэрэг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, **Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 5 жилийн дундаж нийт иргэний хэргийн 10.1 хувь** байна.

Монгол Улсын хэмжээнд 2016 онд 16,8 мянган хос, 2017-2019 онд жилдээ 20,0-21,0 мянган хос гэрлэлтээ бүртгүүлж байсан бол 2020, 2021 онд тус бүр 14,2 ба 16,1 мянга болж буурчээ.

Түүнчлэн 2016 онд 4,0 мянган гэр бүл гэрлэлтээ цуцалсан бол 2020, 2021 онд тус бүр 3,3, 3,4 мянга болж буурчээ.

¹² Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ), 264 дүгээр тал.

Харин 2022 онд 17694 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4515 гэрлэгчид гэрлэлтээ цуцлуусан байна. 2023 оны 1-10 дугаар сард 15,128, 2024 оны мөн хугацаанд 11,186 гэрлэлт бүртгэлт бүртгэгдэж, тус бүр 4102 ба 3692 гэрлэлт цуцалсны бүртгэл бүртгэгджээ.¹³

Эндээс **нийт гэрлэлтийн бүртгэлд оногдох гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ 27-33 хувь** байна гэж дүгнэж болохоор байна.

Гэр бүл цуцлах маргааны тухайд, 2020 онд 3015 маргааныг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь **амжилтгүй буюу 353-т нь буюу 12 хувьд нь л амжилттай эвлэрсэн** байна. 2021 онд **3861 гэр бүлийн хэргийг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь амжилтгүй эвлэрээгүй** байна.

Түүнчлэн гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг 2020 онд 2176 шийдсэн бол мөн онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах тусдаа нэхэмжлэлийг 1333-ыг шийдсэн, 2021 онд гэрлэлт цуцлуулах 2823 хэргийг, хүүхдийн тэтгэлэг гаргуулах 1297 хэргийг тус тус шийдвэрлэсэнг харвал гэрлэлт цуцлуулахад хүүхдийн асуудлыг хамтад нь заавал шийдвэрлэхгүй байна.¹⁴

Хуулийн 132 дугаар зүйлийн 132.4. дэх хэсэгт “Харин Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.” гэж заасан эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нв тогтоогдсон байх нотлох баримтыг нэхэмжлэгчээс шаардаж, нотлох үүрэг нэхэмжлэгчид байснаар хэрхэн уг зохицуулалт зорилгодоо хүрч байгааг шалгана.

Шүүхийн шатанд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэр бүлийн гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээн авахдаа аливаа шаардлага, цензур, холбогдох нотлох баримтыг шаардаж шалтаг заан буцаахгүй байхад анхаарах хэрэгтэй байгааг судлаачид онцолжээ.¹⁵

Хүчирхийлэл үйлдэгдсээр байтал нотлохыг шаардаж, гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх талаарх ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг нь тус тус хүүхдийн болон гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт болсон. Ийнхүү хязгаарлах нөхцөл нь эдгээр хуулийн зохицуулалт зорилгодоо нийцэхгүй байгааг илтгэж байна.

– 2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, 10 шийдвэр буюу 20 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй гаргасан байна.

¹³ Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас 2024.11 сар.

¹⁴ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны албан бичгээр ирүүлсэн статистик тоо мэдээ.

¹⁵ Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, №4, 112 дахь тал.

–2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан байна¹⁶.

Түүврийн аргаар **Shuukh.mn** хуудаснаас гэрлэлт цуцлалттай холбоотой 5 хэргийг түүж судлахад дараах дүр зураг ажиглагдаж байна.

Гэрлэлт цуцлах шалтгаан гэрлэгчид тусдаа амьдарсны улмаас гэрлэлтээ цуцлах болсон. Гэрлэлт цуцлах асуудлаар шүүхийн Эвлэрүүлэн зуучлагчид хандаж байсан боловч эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон байна. Нотлох баримт хэргийн оролцогчид өөрсдөө нотлох баримтаар тайлбар, гэрлэлтийн лавлагаа зэргийг гаргасан. Шүүхээс нотлох баримт гаргаагүй байна.¹⁷

Гэрлэлт цуцлах шалтгаан зан харьцааны хувьд таарч тохирохгүй нөхрийн архи уудгаас болж тусдаа амьдарснаар салах болсон. Нотлох баримтаар талуудын өөрсдийн гаргасан гэрлэлтийн гэрчилгээ, зохигчийн тайлбар, хүүгийн гэрчилгээний хуулбар зэрэг нотлох баримтуудаар тогтоогдсон шүүхээс нотлох баримт цуглуулаагүй. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан боловч гэрлэгчид эвлэрээгүй байна.¹⁸

Зан харилцааны таагүй байдлаас тус тусын амьдралтай болсон. Нотлох баримтаар зохигчдын гаргасан гэрлэлтийн гэрчилгээ, хүүхдийн гэрчилгээ, тайлбар зэрэг авагдсан. Шүүхээс баримт цуглуулаагүй Шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлалын арга хэмжээ амжилтгүй эвлэрээгүй.¹⁹

Хариуцагч өөр хүнтэй хамтран амьдрах болсон учир салах болсон байна.

Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болсон эвлэрээгүй. Талууд гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар нотлох баримтаар гаргаж өгсөн. Шүүхээс нотлох баримт цуглуулаагүй.²⁰

Тусдаа амьдарсны улмаас гэрлэлт цуцлах шалтгаан болсон. Эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон. Нотлох баримтаар гэрлэлт бүртгэлийн лавлагаа, тайлбар авагдсан. Шүүхээс баримт цуглуулаагүй.²¹

Дүгнэхэд, 5 шийдвэрийн 2 нь тусдаа амьдралтай болсон, 2 нь зан харилцаа таарахгүй, 1 нь өөр хүнтэй хамтран амьдрах шалтгааны улмаас гэрлэлт цуцалсан байна. 5 шийдвэрийн хувьд бүгдэд нь эвлэрүүлэн зуучлалаар орсон боловч амжилтгүй

¹⁶ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

¹⁷ Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2020 оны 12 сарын 30 өдөр, дугаар 148/ШШ2021/00005.

¹⁸ Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2019 оны 12 сарын 25 өдөр, Дугаар 142 ШШ2020 00019.

¹⁹ Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017 оны 12 сарын 13 өдөр, Дугаар 648.

²⁰ Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2016 оны 12 сарын 27 өдөр, дугаар 102 шш2017 00041.

²¹ Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, 2020 оны 12 сарын 30 өдөр, Дугаар 148 ШШ2021 00005.

болж, шүүхэд цуцалсан байна. Мөн бүх шийдвэрт талууд нотлох баримт гэж лавлагаа гаргаж, шүүхээс огт материал цуглуулж, шалгалт хийгээгүй байна.

Харьцуулсан судалгаа

Франц Улс²²

Гадаад улсын туршлагаас харвал, Франц улсын хувьд гэр бүлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Иргэний хуулийн 255 дугаар зүйлд зааснаар шүүгч эвлэрүүлэн зуучлах ажиллагааг гэрлэгчдэд санал болгож, талуудын зөвшөөрлийг авсны үндсэн дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хөтлөн явуулах гэр бүлийн эвлэрүүлэн зуучлагчийг томилно гэжээ.

Эвлэрүүлэн зуучлал талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих зарчмын хүрээнд оролцогчд хүсэл зоригоо илэрхийлэх, үүгээр шийдвэрлүүлэхийг зөвшөөрөх, татгалзах эрхтэй байх үндсэн зарчим Франц улсын хуульд тусгагджээ.

БНСУ²³

БНСУ-ын хувьд гэрлэлтийг харилцан тохиролцох буюу захиргааны журмаар шүүхэд хандан, шүүхийн журмаар цуцлах гэж 2 янзын журам байдаг.

Захиргааны журмаар цуцлах гэж гэрлэгчид харилцан тохиролцсон бол шүүхэд хандах гэхдээ хандахаас өмнө зөвөлгөө авсан байхыг шаарддаг.

Мөн зөвшилцөх хугацаа болох хүүхэд байгаа бол 3 сар, хүүхэд байхгүй бол 1 сар байна.

Ийнхүү цуцлахдаа заавал хүүхдийн хууль ёсны асран хамгаалалт, тэжээн тэтгэх тухай тохиролцоог баталгаажуулсан шийдвэрийг гаргадаг.

Шүүхийн журмаар цуцлуулах нэхэмжлэл гаргахад эвлэрүүлэн зуучлалаар заавал орохыг шаарддаг бөгөөд хэрэв ороогүй бол шүүхээс эвлэрүүлэн зуучлалд шилжүүлдэг боловч агуулга нь бодит байдлаар эвлэрч цуцлуулахгүй байхад биш **эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд гэрлэлтээ цуцлуулах тохиролцоонд хүрэхээр зорьдог**. Энэ нь шүүхийн шатанд эвлэрсэнтэй адилд тооцогдож, цуцлалттай холбоотой хүүхэд, эд хөрөнгийн асуудлаар тохиролцсоноор гэрлэлтийг цуцалдаг.

Гэр бүлийн шүүх тухайн нөхцөл байдал, цуцлуулах нөхцөл байдлыг шалгаж шалгах ажиллагаа явуулж, шүүх өөрөө давхар нотлох үүрэгтэй байдаг.

Гэрлэлт цуцлуулах үндэслэлүүдийг заасан байдаг бөгөөд зөвхөн эдгээр үндэслэлээр л гэрлэлт цуцалдаг. Дүгнэвэл, гэрлэлт цуцлах үндэслэл бүрдсэн эсэхийг талууд нотлохоос гадна шүүх өөрөө мөрдөн шалгах ажиллагаа явуулж цуцлах үндэслэл бүрдсэн эсэхийг шалгаж, нотолдог.

Эвлэрүүлэн зуучлал ч мөн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, цуцлах үндэслэл бүрдсэн бол хүүхэд, хөрөнгө гэх зэрэг цуцлалттай холбоотой бусад асуудлаар талууд тохиролцоонд хүрвэл, эвлэрлийг баталж, гэрлэлт цуцалдаг.

²² Франц улсын Иргэний хуулийн 255 дугаар зүйл.

²³ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэх тухай хууль
https://elaw.klri.re.kr/eng_service/lawViewContent.do?hseq=18173

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд гэрлэлтээ цуцлуулах тохиролцоонд хүрсэн бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэлд тусгаснаар эвлэрсэн гэж үзнэ.²⁴ Энэхүү эвлэрэл нь шүүхийн хуралдааны явцад эвлэрсэнтэй адил хууль зүйн үр дагавартай байна.²⁵

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах өдөр ирээгүй, талууд тохиролцоонд хүрч чадаагүй, талуудын тохиролцоог зүй бус гэж үзвэл эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эрхэлсэн шүүгч холбогдох шийдвэрийг гаргана.²⁶

Дээрх шийдвэртэй холбогдуулан талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш 2 долоо хоногийн дотор гомдол гаргаагүй, гомдлоосоо татгалзсан, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шийдвэр хүчин төгөлдөр болсон шүүхийн шатанд эвлэрсэн тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсонтой адил хууль зүйн үр дагавар бий болно.²⁷

Япон Улс²⁸

Япон улсын хувьд гэрлэлтийг харилцан тохиролцох буюу захиргааны журмаар шүүхэд хандах, шүүхийн журмаар цуцлах гэж 2 янзын журам байдаг.

Захиргааны журмаар гэрлэлт цуцлахад харилцан тохиролцсон байхаас гадна хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчийн талаар харилцан тохиролцсон тухайгаа хүсэлтдээ дурдахыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, гэрлэгчид харилцан тохиролцоогүй бол захиргааны журмаар гэрлэлт цуцлахгүй.²⁹

Гэрлэлт цуцлуулах үндэслэлүүдийг заасан байдаг бөгөөд энэхүү үндэслэлээр л зөвхөн гэр бүл цуцалдаг.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах ч гэрлэлт цуцлуулах тохиролцоонд хүрч болдог. Өөрөөр хэлбэл, талууд бодитоор гэрлэлтээ цуцлахгүй болж эвлэрэхэд биш гэрлэлт цуцлалтаа эвийн журмаар хийж, хүүхэд, эд хөрөнгийн асуудлаа эвээр тохиролцож, гэрлэлтээ цуцлахад эвлэрүүлэн зуучлалын зорилго нь чиглэж байна.

Мөн Япон Улсын хуульд гэрлэлт цуцлах үндэслэлүүдийг заасан байдаг.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.

²⁴ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#>

²⁵ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#>

²⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12, 49 дүгээр зүйл. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30,32 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=213779&efYd=20200305#0000>

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 225 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249995&efYd=20231019#0000>

²⁷ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дүгээр зүйл, 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 34 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=213779&efYd=20200305#0000>

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 231 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249995&efYd=20231019#0000>

²⁸ Японы Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.

²⁹ Японы Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль.

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох буюу хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох зэрэг, түүнчлэн хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох зэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх нь зорилгодоо хүрч байгаа эсэх?

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт гэр бүлийн холбогдолтой зарим хэргүүдийг шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр заасан. Үүнд, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хамгаалалт, харгалзан дэмжигчээр томилсныг хүчингүйд тооцох зэрэг болно.

Гэвч эдгээр хүсэлтийг шийдвэрлэхтэй холбогдох хянан шийдвэрлэх ажиллагааг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх гэж заасан ч **онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхэд хугацааны хувьд ердийн журмаар хянан** шийдвэрлэхээс өөрөөр заасан зохицуулалт байхгүй болно.

Харин ИХШХШТХ-ийн 82 дугаар зүйлийн 82.1.3, 82.1.6 дахь заалтад заасны дагуу гэр бүлийн холбогдолтой нэхэмжлэл, түүнчлэн онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хүсэлтийг анхан шатны шүүхийн **шүүгч дангаар шийдвэрлэхээр** заасан байна.

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох буюу эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, хүүхдийн эцэг, эх тогтоох, хүүхдээ тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох зэргийг оролцуулаад ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэсэн хэргийн хувьд 2020 онд 12,672, 2021 онд 7313, 2022 онд 7245, 2023 онд 5704 зэргээр нийт шийдвэрлэсэн хэрэг буурсан байх бөгөөд гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааны тоонд орохгүй байгаа болно.

ИХШХШТХ-ийн Арван хоёрдугаар бүлгээр гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх журамд хамаарах 125-132 дугаар зүйл нь гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаан гэж гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл, түүнтэй холбоотой тэжээн тэтгэх, эд хөрөнгө хуваах асуудлыг шийдвэрлэхэд зориулсан буюу гэр бүлийн холбогдолтой хэрэг гэдэгт гэрлэлт цуцлуулахтай холбоотой хэрэг байдлаар явцуу хуульчилжээ.

Түүнчлэн ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйл буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх асуудалд гэрлэлт цуцлалтын нэхэмжлэлээс бусад бүх асуудлыг /гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, тэжээн тэтгэх, эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, эцэг, эх тогтоох, үрчлэлт болон асран хамгаалалт, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүй болгох /багтаажээ. Гэтэл эдгээр асуудлыг ямар журмаар, хэрхэн, ямар үе шатуудыг гүйцээж, шүүхээс нотлох үүрэг юу байх зэргээр нарийн процессыг огт тусгаагүй байна.

Ингэж гэр бүлийн холбогдолтой хэргүүдийг ач холбогдолгүй байдлаар гэр бүлийн, онцгой ажиллагааны гэж хувааж дангаар шүүх шийдэж, талуудаас зөвхөн

нотлох баримт гэж лавлагаа, тодорхойлолт гаргуулах байдлаар идэвхгүй шийддэг процесстой хэвээр байвал гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, энэ ажиллагаанаас хойш ч хүүхдийн эрх зөрчигдөх, гэрлэгчдэд шударгаар гэр бүлийн хэрэг нь шийдэгдэхгүй байхад нийгэмд гэр бүлийн хэргийг шийдлээ гээд цуцаллаа гээд үр дагавар нь их биш гэж тайвшрах, гэр бүл цуцлалт ихсэхэд нөлөөлнө.

Эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах талаарх Shuukh.mn хуудсан дахь түүврийн аргаар цуглуулсан дараах хэргүүдийг судлахад нэхэмжлэгч нь эцэг, эхийн аль нэг, эсхүл төрөл садангийн хүн байх бөгөөд шалтгааны хувьд ихэнх тохиолдолд хүүхдийг эрхийг зөрчиж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн байна. Мөн нотлох баримтаар Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан нөхцөл байдлын үнэлгээ, хүүхэд хамгаалах түр байранд байсан мэдээлэл, хүүхдийн санал зэргийг авчээ.

Нэхэмжлэгч асран хамгаалагч ах байх бөгөөд шалтгаан нь хүүхдийн эцэг гэр бүлийн хамаарал бүхий хүүхдүүдтэйгээ байнгын харгис хэрцгий харьцаж догшин авирладаг, өөрийн эхнэр Д. 11 жил байнгын гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж амь насанд нь хүрсэн. Хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундааны зүйл байнга хэрэглэдэг.

- Нотлох баримтаар талуудын тайлбар, Асран хамгаалагч тогтоох тухай захирамж, монгол хэлний хичээлийн зохион бичлэг, Хүүхэд хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягт, хүүхдээс тайлбар авсан байна. Хүүхдийн эцэг олон удаагийн ял шийтгэлтэй этгээд ба түүнд оноосон шүүхийн шийдвэрт үндэслэсэн байна.³⁰ Нэхэмжлэгч асран хамгаалагч авга эгч байх бөгөөд шалтгаан нь хүүхдээ нялх байхад орхиж явж, нэг удаа хайрлах хамгаалах харилцаа тогтоохыг оролдож байгаагүй. Нотлох баримт шүүхээс гаргаагүй, зохигчдын тайлбар хүүхдийн төрсний гэрчилгээ авагдсан байна.³¹

- Нэхэмжлэгч авга ах бөгөөд шалтгаан нь эцэг нас барж, эх нь өөр хүнтэй гэр бүл болсон. Нотлох баримт хүүхдийн төрсний гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, гэрлэлтийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, нас барсны гэрчилгээний хуулбар, нэхэмжлэгчийн шүүх хуралдаанд гаргасан тайлбар, хариуцагчийн шүүхэд ирүүлсэн тайлбар авагдсан.³²

- Шалтгаан нь хүүхдүүдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхгүй, үл хайрхан хүчирхийлэлд өртүүлж байгаа. Мөн архины гүн хамааралтай. Сумын хамтарсан багийн хурлын тэмдэглэл, аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэл, нөхцөл байдал, хэрэгцээний үнэлгээ, хүүхдүүдийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ, хүүхдийн эрх, зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягт, хамтарсан багийн тэмдэглэл, нөхцөл байдлын үнэлгээ, хүүхдийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ, аюулгүй байдал, төлөвлөгөө, түр хамгаалах байрны үйлчилгээнээс нэгтгэгдэж байгаа кейсийн зөвлөмж, түр

³⁰ Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2021 оны 10 сарын 07 өдөр, Дугаар 103/ШШ2021/00336.

³¹ Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2020 оны 04 сарын 03 өдөр, Дугаар 290.

³² Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2019 оны 02 сарын 25 өдөр, Дугаар 99.

хамгаалах байрнаас үзүүлсэн үйлчилгээний жагсаалт зэргийг нотлох баримтаар авсан.³³

- Нэхэмжлэгч хүүхдийн ээж байх ба шалтгаан нь үл хайхрах байдал, хүчирхийлэл дарамтад удаа дараа өртсөн, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчсөн, сургуульд сурдаггүй завсардсан.Нотлох баримтаар тайлбар, хүүхдийн гэрчилгээ, шүүхээс хүүхдийн саналыг асуусан тайлбар, шүүхийн шийдвэрүүдэд үндэслэсэн. Нэхэмжлэгч талд шийдвэр гарсан.³⁴

Тухайлбал, онцгой ажиллагааны журмаар шийддэг үрчлэлтийг хүчингүй болгож шийдвэрлэсэн shuukh.mn дээрх дараах шүүхийн шийдвэрүүдийг түүврийн аргаар цуглуулж, дүгнэв.

Үрчлүүлэгч нэхэмжлэл гаргасан. Хүүхдийг нэхэмжлэгч буюу үрчлүүлэгчийн асрамжид үлдээж шийдвэрлэсэн.³⁵

Шалтгаан нь үрчлэгдэгч хүүхэд ааваараа овоглуулахын тулд шүүхэд хүсэлт гаргасан. Нэхэмжлэгчийн талд шийдвэрлэсэн. УБЕГазрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2004 оы 11 дүгээр сарын 05-ны өдрийн үрчилсний бүртгэлийн лавлагааг авсан байна.³⁶

Шалтгаан нь хүүхдийн эх сурч боловсрох амьдралын шаардлагаар үрчлүүлсэн. Нөхцөл байдал дээрдэж хүүхдээ өөр дээрээ авах хүсэлтэй. Нэхэмжлэгч нь хүүхдийн ээж буюу үрчлүүлэгч, төрсөн эцэг эхийн асрамжид шилжүүлж шийдвэрлэсэн.Нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүх гэрчээр асууж гэрчийн мэдүүлэг нотлох баримтыг цуглуулсан.³⁷

Шалтгаан нь хүүхдийн төрсөн ээж өөрийн ээжид үрчлүүлсэн. Үрчлэгч өндөр настай тул одоо хүүхдийг өөр дээрээ авах шалтгаантэй. Нэхэмжлэгч нь хүүхдийн төрсөн эх үрчлүүлэгч байв. Шүүхээс баримт цуглуулаагүй буюу нэхэмжлэгч хариуцагч нарын тайлбар, үрчилсний бүртгэлийн лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа зэрэг авагдсан.³⁸

Шалтгаан нь охиноо асарч чадахгүй өөрийн эцэгт үрчлүүлсэн. Нэхэмжлэгч нь хүүхдийн эцэг буюу үрчлүүлэгч бөгөөд төрсөн эцгийн асрамжид үлдээж шийдвэрлэсэн.

³³ Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2025 оны 01 сарын 03 өдөр, Дугаар 307/ШШ2025/00029.

³⁴ Дорнод аймаг дахь сум дундын анхан шатны шүүх, 2023.03.23, Дугаар 138 ШШ2022 00290.

³⁵ Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2020 оны 11 сарын 27 өдөр, Дугаар 133 ШШ2020 00816.

³⁶ Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2025 оны 01 сарын 09 өдөр, Дугаар 314 ШШ2025 00014.

³⁷ Ховд аймгийн булган сум дахь сум дундын шүүхийн шийдвэр, 2021.03.24, дугаар 154 шш2021 00074.

³⁸ Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх, 2020.07.03, дугаар 133 шш2020 00505.

Нотлох баримтаар зохигчдын тайлбар, үрчлэлтийн гэрчилгээний хуулбар, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар зэрэг авагдсан.³⁹

Дүгнэвэл, ихэнх тохиолдолд үрчлүүлэгч ойрын хүмүүсдээ үрчлүүлсэнээ цуцалж, буцааж авья гэсэн нэхэмжлэл гаргаж, шүүх нотлох баримт цуглуулахгүй шууд үрчлүүлэгчид буцааж өгч байна. Мөн үрчлэгч хүүхэд өөрөө нэхэмжлэл гаргасан тохиолдол байна.

Харьцуулсан судалгаа

Бусад улсын туршлагаас үзвэл, БНСУ, Япон Улсын хувьд, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах, гэрлэлттэй адилтгах харилцаанд гэр бүлийн дундын эд хөрөнгө хуваахтай адил зарчмаар хуваах, үрчлүүлэх, үрчлэлтийг хүчингүйд тооцох, асран хамгаалагчийг томилох, эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, хүүхдийн хуваарьт хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах зэргийг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай бие даасан хуулиараа зохицуулж байна.

Мөн эдгээр төрлийн нэхэмжлэлүүдэд гэрлэгчид төдийгүй, хүүхэд, төрөл садангийн хүн, прокурор, орон нутгийн байгууллага нэхэмжлэл гаргах эрхтэй буюу гуравдагч этгээдийн нэхэмжлэл гаргах эрх, түүнчлэн шүүх өөрийн санаачилгаар авч болох арга хэмжээ, тухайлбал мөрдөн шалгах, бусад этгээдээс баримт, нотолгоо шаардах зэргийг тусгажээ.

БНСУ-д үрчлэлтийг шүүх, үрчлэлтийг хүчингүй болгох асуудлыг мөн шүүх шийддэг бөгөөд шүүхээс ажиллагаа нарийн хийгддэг бөгөөд хуульд үрчлэх үндэслэл, үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэлийг тодорхой заасан байдаг. Манай улсын хувьд үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг онцгой ажиллагааны журмаар шийддэг бөгөөд төдийлөн нарийн нотлох ажиллагаа хийгдэхгүй байна.

Доор БНСУ-ын үрчлэлт, үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг хэрхэн шийддэгийг авч үзье.

БНСУ-ын хувьд үрчлэлт хүчин төгөлдөр болохын тулд юуны өмнө талууд хүлээн зөвшөөрсөн байхыг шаардана.⁴⁰ Талуудын тохиролцоо байхгүй хүсэл зоригийн илэрхийлэл баталгаажуулж бол хууль зүйн үр дагавар бий болох боломжгүй бөгөөд **үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл** болно.⁴¹ Энэхүү хүсэл зоригийн илэрхийлэл нь үрчлэлттэй холбоотой хүсэлт гаргах, хүсэлтийг хүлээн авч шийдвэр гаргах явцад мөн хүчин төгөлдөр хэвээр байхыг шаарддаг байна.

Хүүхдийг үрчлэх бол Гэр бүлийн шүүхийн зөвшөөрөлийг авах ёстой⁴² бөгөөд Гэр бүлийн шүүх нь үрчлэгдэх хүүхдийн ирээдүй аж амьдралын нөхцөл байдал, үрчлэх

³⁹ Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийдвэр, 2019.02.27, Дугаар 52.

⁴⁰ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, [대법원 2004. 4. 9. 선고 2003므2411 판결](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(2003%EB%AF%802411)), [https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(2003%EB%AF%802411\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(2003%EB%AF%802411))

⁴¹ БНСУ-ын Иргэний хуулийн 883 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

⁴² БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

болсон шалтгаан, үрчлэн авч буй этгээдүүдийн хүүхэд өсгөн хүмүүжүүлэх болон асран хамгаалах чадвар, бусад нөхцөл байдлыг харгалзан үзээд үрчлүүлэх зөвшөөрөл олгохгүй байж болно.⁴³

Гэр бүлийн шүүх нь үрчлэлттэй холбоотой шийдвэр гаргахдаа эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар өөрийгөө илэрхийлэх боломжгүй байхаас бусад тохиолдолд заавал дор дурьдсан хүний саналыг авах ёстой.⁴⁴

1. 13 дээш насны үрчлэгдэгч
2. Үрчлэгдэж буй хүний хууль ёсны төлөөлөгч
3. Үрчлэгдэж буй хүний эцэг, эх (Иргэний хуулийн 870 дугаар зүйлд⁴⁵ заасны дагуу эцэг, эхийн зөвшөөрөл шаардлагатай тохиолдолыг ойлгоно)
4. Үрчлэгдэгчийн эцэг, эхийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч
5. Үрчлэгч
6. Үрчлэнийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч

Гэр бүлийн шүүх үрчлэгдэгчийн эрх ашгийн төлөө шаардлагатай гэж үзвэл доор дурдсан мэдээллийг гаргуулахаар холбогдох байгууллагад даалгаж болох бөгөөд тухайн байгууллага нь хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй бол холбогдох мэдээллийг шүүхэд гаргаж өгөх ба гаргаж өгөөгүй бол хариуцлага оногдуулдаг.⁴⁶

1. Үрчлэгчийн оршин суугаа хаяг, гэр бүлийн байдлыг тодруулах зорилгоор хот, дүүрэг, сумын дарга нарт хандан тодорхойлолт гаргуулах
2. Үрчлэгчийн орлогыг тодруулах зорилгоор татварын байгууллагын даргад хандан хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын тайлан мэдээлэл гаргуулах
3. Үрчлэгчийн гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байсан эсэхийг тодруулах зорилгоор цагдаагийн байгууллагын даргад хандан тодорхойлолт гаргуулах
4. Үрчлэгчийн тэжээн тэтгэх чадвар чадамж, сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн байдлыг тодруулах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар эрүүл мэндийн байгууллагын дарга мөн Иргэдийн эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Иргэдийн эрүүл мэндийн даатгалын байгууллагын даргад хандан эмчилгээний түүхтэй холбоотой мэдээллийг гаргуулах

БНСУ-ын Иргэний хуульд заасан үрчлэлттэй холбоотой журмыг зөрчсөн дараах үндэслэл байна гэж үзвэл Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай нэхэмжлэл гаргаж болно.

1. Насанд хүрээгүй хүн үрчлэгч болсон болон⁴⁷ БНСУ-ын Иргэний хуульд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох дараах үндэслэл⁴⁸ байгаа бол үрчлэгч,

⁴³ БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

⁴⁴ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.9 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#J45:9>

⁴⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.9 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#J45:9>

⁴⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 866 дугаар зүйл. Үрчлэгчийн чадамж.

Үрчлэгч насанд хүрсэн байна.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁴⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйл. Үрчлэлтийг хүчингүйд тооцох

үрчлүүлэгч болон тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч эсхүл цусан төрлийн хүн шүүхэд нэхэмжлэл гаргана.⁴⁹

2. Иргэний хуулийн 866,869.1,869.3.2, 870.1, 871.1, 873.1, 874 дэх зүйлийг зөрчсөн бол⁵⁰
3. Үрчлэгч эсхүл үрчлүүлэгч нь үрчлэлтийн үед хэн аль нэг талын сөрөг ноцтой зан байдал болон бусад ноцтой байдлын талаар мэдээгүй бол⁵¹
4. Хууран мэхэлж эсхүл албадлагаар үрчлэлтийг хүлээн зөвшөөрүүлсэн бол⁵² Хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг авалгүй 13 наснаас дээш насанд хүрээгүй хүнийг үрчилж авсан бол⁵³
5. Үрчлэгдэгч 13 хүртэл насны насанд хүрээгүй хүүхэд эсхүл 13 дээш насны насанд хүрээгүй хүүхдийг түүний эцэг эхийн зөвшөөрөлгүй үрчилсэн бол үрчлэгдэгч болон үрчлэлтийг зөвшөөрөх эрхтэй хүн үрчлэлтийг хүчингүй болгуулахаар⁵⁴
6. Насанд хүрээгүй хүүхдийн эцэг эх нь эцэг эх байх эрхээ шүүхээр хасуулсан эсхүл хаана байгаа нь тодорхойгүй шалтгаан байхгүй байхад тэдний зөвшөөрлийг авалгүй үрчилсэн бол⁵⁵ үрчлэгдэгч, эсхүл зөвшөөрөл өгөх эрхтэй этгээд Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар⁵⁶
7. Насанд хүрсэн асран хамгаалуулагч өөрийн асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр үрчилж авсан эсхүл үрчлэгдсэн⁵⁷ бол насанд хүрсэн асран хамгаалуулагч, эсхүл түүний асран хамгаалагч нь Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана.⁵⁸
8. Эхнэр, эсхүл нөхөртэй хүн хамт үрчлээгүй, эсхүл аль нэг талынхаа зөвшөөрлийг авалгүй үрчлэгдсэн⁵⁹ бол эхнэр, эсхүл нөхөр нь Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

⁴⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 885 дугаар

зүйл <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵¹ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵² БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵³ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 869 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 870 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 870 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 873 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 887 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 874 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3.

ИХШХШтХ-ийн зарчим гэр бүлийн холбогдолтой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчилж байгаа нь зорилгодоо хүрсэн эсэх?

Нийтийн болон хувийн эрх зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарчим ялгаатай хэдий ч гэр бүлийн холбогдолтой хэрэгт диспозитив зарчмаас гадна шүүхээс хянан шалгах, нотлох баримт цуглуулах үүрэг бусад улсуудад байгааг харгалзан одоогийн иргэний процессын хууль дахь ерөнхий зарчим гэр бүлийн холбогдолтой хэрэг маргаанд тохиромжтой эсэх, зорилгодоо хүрсэн эсэхийг шалгалаа.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах, хугацааны талаарх ердийн журам гэр бүлийн холбогдолтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд хамаарч байгаа зохицуулалтуудын зорилгодоо хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог бол диспозитив болон мэтгэлцэх зарчмууд мөн. Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь "...диспозитив буюу зохигчдын санаачилга, хүсэлтийн үндсэн дээр явуулах болон мэтгэлцэх зарчимд үндэслэдэг явдал юм."⁶⁰ Энэ нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, зохигч эвлэрэх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх зэргээр илэрч хэрэгжихээс гадна диспозитив зарчмыг шууд үгчлэн хуульчлаагүйгээс ойлголтын янз бүрийн асуудал үүсгэж болох бөгөөд мэтгэлцэх зарчмыг ИХШХШтХ-ийн 6 дугаар зүйлд зохицуулсан.⁶¹

ИХШХШтХ-ийн 6 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр, уг зарчим бүх шатанд хэрэгжихээр заасан.

Мөн хэсэгт зохигч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нь хэргийн үйл баримт, гэм буруу байгаа эсэхийг нотлох буюу үгүйсгэх замаар мэтгэлцэх, гагцхүү бодит байдалд нийцсэн тайлбар өгөх, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт гаргах үүрэгтэй.

Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлагын талаарх тайлбарыг гагцхүү зохигч талууд гаргана. Хуулийн 133 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэрэгт энэ зүйл хамаарахгүй.

Үүнд, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох /садан, төрлийн холбоо, бусдын асрамжинд байгаа эсэх, төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, хүүхдээ тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх/, хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах, сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас

⁶⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, 289 дүгээр тал.

⁶¹ Мөн тэнд.

хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох зэрэг асуудалд мэтгэлцэх зарчим хэрэгждэггүй болно.

Харьцуулсан судалгаа

БНСУ

Гэр бүлийн шүүхийн шалгах ажиллагаа

Гэр бүл болгон амьдралын нөхцөл байдал зэргээс шалтгаалж гэр бүлээ цуцлуулахад хүргэсэн шалтгаан нь өөр өөр байдаг тул эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахдаа Гэр бүлийн шүүх энэхүү хувийн болон тодорхой нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгцээ шаардлага бий болдог тул эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаас өмнө болон шүүхэд гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ гэр бүлийн бодит байдлын талаар шалгах ажиллагааг явуулдаг.⁶²

Энэхүү шалгах ажиллагааны хүрээнд шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллага, захиргааны байгууллага болон бусад байгууллага эсхүл хувь хүнээс (банк, сургууль гэх мэт) гэрлэгчдийн дансны мэдээлэл, хөрөнгийн байдал, орлого, боловсролын байдал болон бусад шаардлагатай мэдээллийг нягтлан шалгаж болно.⁶³

Гэрлэлт цуцлагдсан тохиолдолд гэрлэлт цуцлуулахад хүргэсэн буруутай талаас эдийн бус гэм хорыг нэхэмжилж өөрт учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан нөхцөл нь нөгөө талынхаа сэтгэл санаанд гэм хор учруулсан гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх бөгөөд энэхүү гэм хорыг мөнгөн хэлбэрээр гаргуулах боломжтой байна.⁶⁴

Гэм хорын нэхэмжлэлийг шүүхийн журмаар, захиргааны буюу харилцан тохиролцож гэрлэлт цуцлуулах, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулах, гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгох тохиолдолд нэгэн адил гаргах боломжтой байхаар хуульчилсан байна.⁶⁵⁶⁶ Гэхдээ талууд харилцан буруутай байх тохиолдолдыг харгалзан үзэх ёстой⁶⁷ бөгөөд харилцан буруутай байх тохиолдолд гом хорын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэнэ.⁶⁸

Гэрлэлт цуцлуулахад нэхэмжлэгч нэхэмжлэл гаргаагүй ч шүүх өөрийн санаачилгаар тэжээн тэтгэх, тэтгэлгийн асуудлыг заавал шийддэг.

⁶² БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл, 56 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

⁶³ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 3 дугаар зүйл(Дээд шүүхийн журам).

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=210085&efYd=20190802#0000>

⁶⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 806 дугаар зүйл, 843 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁶⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 806 дугаар зүйл, 825 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000Й>

⁶⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1.1. 다, <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁶⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 396 дугаар зүйл, 763 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁶⁸ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1994. 4. 26. 선고 93므1273 판결, [https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(93%EB%AF%801273\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(93%EB%AF%801273))

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах үед хүүхдийг тэжээн тэтгэх асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд харилцан тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн шүүх нэхэмжлэлийн дагуу эсхүл өөрийн санаачлагаар тэжээн тэтгэхтэй холбоотой шийдвэр гаргана.⁶⁹

1. Тэтгэлэг төлөгчийг тогтоох
2. Тэтгэлэгийн хэмжээг тогтоох
3. Насанд хүрээгүй хүүхэдтэй уулзах эрх, уулзалтын арга хэлбэрийг тогтоох

Гэр бүлийн шүүх нь тэжээн тэтгүүлэгчийн ирээдүй, хэрэгцээ шаардлагыг харгалзан шаардлагатай гэж үзвэл эцэг, эх болон тэжээн тэтгүүлэгч, прокурорын хүсэлтээр мөн өөрийн санаачлагаар тэжээн тэтгэх асуудлын өөрчлөх, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг авч болно.⁷⁰

Энэ мэтчилэн Монгол Улсад онцгой ажиллагаагаар шийддэг үрчлэлтийг хүчингүйд тооцох зэрэг асуудал нь гэр бүлийн хэрэг маргаанд ордог бөгөөд шүүх хуульд заасан үндэслэл бүрдсэн эсэхийг шалгадаг, баримт гаргуулан авдаг. Мөн гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлд хүүхдийн тэтгэлэг нэхэмжлээгүй байсан ч өөрийн санаачлагаар шүүх уг асуудлыг заавал шийддэг зэрэг шүүхийн идэвхтэй, шалгах ажиллагааг гэр бүлийн холбогдолтой хэрэгт шаарддаг байна.

ХБНГУ

Шүүх шийдвэр гаргах үндэслэл болох нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зарим шаардлагатай шалгах ажиллагааг явуулах ёстой. *Шүүхийн зарим хянан шалгах ажиллагаа(125 дугаар зүйл)*

Гэрлэлт цуцлуулах тухай болон гэр бүлийн бусад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хамт явуулна. Гэр бүлийн бусад маргаанд тэтгэвэр хуваах, насанд хүрээгүй хүүхдийн тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой асуудал, мөн хуульд заасан тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой маргаан, гэр бүлийн хөрөнгийн маргаан, гэр бүлийн оршин суух газрын талаарх маргаан зэргийг ойлгоно. *Гэрлэлт цуцлалт болон бусад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хамт явуулах(133 дугаар зүйл)*

Хүүхдийн оршин газар, хүүхэдтэй уулзах, шилжүүлэх авах болон эцэг тогтоох зэрэг хүүхдийн эрх ашиг сонирхолд шууд нөлөөлөхүйц ажиллагааг тэргүүн ээлжинд яаралтай шийдвэрлэнэ. Энэхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээс хойш 1 сарын дотор шийдвэрлэх бөгөөд хурал явуулах өдрийг талуудтай зөвшилцөж болно. Шүүх хурал явуулах өдрийг өөрчлөх зайлшгүй шалтгаан байвал өөрчлөх боломжтой бөгөөд өөрчлөх тухай хүсэлт гаргасан бол шалтгаанаа заавал тайлбарлаж нотолно. *Зарим хянан шийдвэрлэх ажиллагааг тэргүүн ээлжинд явуулах зарчим(151 дүгээр зүйл)*

Мөн адил шүүхээс нөхцөл байдлыг тогтоох зорилгоор шаардлагатай ажиллагааг явуулдаг байна. Мөн гэрлэлт цуцлуулахтай хамт шийдэх бүх асуудлыг, ялангуяа хүүхдийн асуудлыг яаралтай шийддэг байна.

⁶⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 1,2,4 дэх хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэх талаарх зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Энэхүү зохицуулалтаар шүүх зарим өсвөр насны шүүгдэгчийн үйлдсэн хэргийг шийдвэрлэхдээ хаалттай, эсхүл нээлттэй шийдвэрлэж болохоор байгаа болно. Тэгвэл гадаад улсын туршлагаар нээлттэй байдлыг зөвшөөрдөг эсэх талаар судлан танилцуулъя.

Япон Улс

Шүүх хуралдааныг явуулахдаа эелдэг зөөлөн уур амьсгалыг бүрдүүлж, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийг өөрийн буруу зан үйлийн талаар эргэцүүлэн бодоход түлхэц өгөх ёстой.⁷¹ Шүүх хуралдааныг хаалттай явуулна.⁷²

БНСУ

Шүүх хурлыг өсвөр насны хүүхдийн ирээдүйн төлөө хаалттай явуулах⁷³ бөгөөд мөн тухайн хүүхдийн хувийн мэдээлэл бүхий мэдээллийг тараахыг хуулиар хориглодог байна.⁷⁴

Өсвөр насны хүүхдийг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны чиг үүргээ биелүүлэхэд бүхий л захиргааны байгууллага, сургууль, эмнэлэг зэрэг нийгмийн бүхий салбарыг хамран хамтран ажиллах шаардлагатай.⁷⁵

Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэх, бодит нөхцөл байдлыг тогтоох зорилгоор анагаах ухаан, сэтгэл судлал, боловсрол судлал болон бусад салбарын мэргэжлийн дүгнэлтийг ашиглах ёстой байдаг.⁷⁶

⁷¹ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

⁷² Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

⁷³ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011헌마232 결정.

⁷⁴ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 68 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

⁷⁵ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 28 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

⁷⁶ БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011헌마232 결정.

Бусад чухал асуудал

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.

Шүүх байгуулах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Тэгвэл, хүүхдийн хэргийг мөн дээрх шүүх хянан шийдвэрлэхээр байна.

Монгол Улсын хувьд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх буюу Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан хэргээр 2018 онд 99, 2019 онд 210, 2020 онд 101, 2021 онд 99, 2022 онд 97, 2023 онд 99 хэргийг тус тус Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн байна.⁷⁷ Мөн Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл болох Хүнийг санаатай алах гэм хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр 2.8-д зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан хэргийг 2020 онд 17, 2021 онд 17, 2022 онд 15, 2023 онд 15 хэргийг тус тус шүүхээс шийдвэрлэсэн байна.⁷⁸

Гэмт хэргийн улмаас хохирсон өсвөр насны хүүхдийн тоо 2020 онд 757, 2021 онд 712, 2022 онд 815, 2023 онд 823 байна.⁷⁹

Зөрчлийн тухай хуулиар өсвөр насны хүүхэд шийтгүүлсэн тоон мэдээг авч үзвэл, 2020 онд 40, 2021 онд 24, 2022 онд 90, 2023 онд 120 байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс өсвөр насны хүнд ял шийтгүүлсэн тоо 2020 онд 228, 2021 онд 125, 2022 онд 203, 2023 онд 222 байна.⁸⁰

Манай Улсын хувьд хүүхэд хохирогч, шүүгдэгч болсон, мөн гэр бүлийн хүчирхийллийн эрүү, зөрчлийн хэргийг Гэр бүл, хүүхдийн шүүх шийдэх бол нийт ойролцоогоор 1300 эрүү, зөрчлийн хэргийн харьяалал тус шүүхэд шилжихээр байна.

Бусад улсад ямар хэргийг гэр бүл, хүүхдийн шүүх шийддэгийг судалвал, БНСУ, Япон Улсын хувьд гэр бүлийн хувийн эрх зүйн хэрэг маргааныг Гэр бүлийн шүүхэд харьяалан шийдвэрлэж байхад, хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн эрүүгийн хэргийн шүүхээр хянан шийдвэрлэхээс илүүтэй Гэр бүл, хүүхдийн шүүхэд харьяалан шийдвэрлэж байна. Тухайлбал, БНСУ, ХБНГУ, Япон улсын тухайд Гэр бүлийн шүүхээр насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг буюу хүүхэд гэмт хэрэг үйлдэхэд тусгайлсан журам бий болгосон

⁷⁷ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс албан бичгээр ирүүлсэн шүүхийн статистик мэдээ 2018-2023 он.

⁷⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 01/1808 тоот албан бичгээр ирүүлсэн шүүхийн статистик мэдээ 2020-2023 он.

⁷⁹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 01/1808 тоот албан бичгээр ирүүлсэн шүүхийн статистик мэдээ 2020-2023 он.

⁸⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 01/1808 тоот албан бичгээр ирүүлсэн шүүхийн статистик мэдээ 2020-2023 он.

байна. Харин хүүхэд хохирогч болсон тохиолдолд шүүгдэгч нь насанд хүрсэн этгээд байх тул тус шүүхээр шийдвэрлэдэггүй, ердийн журмаар шийддэг байна.

ДҮГНЭЛТ

Дээрх судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Иргэний хэрэг шүүхээс үүсгэхээс өмнө болон дараа эвлэрүүлэн зуучлалаар заавал орох шаардлага байгаа нь талуудын сайн дурын үндсэн дээр эвлэрүүлэн зуучлал явуулах зарчимтай нийцэхгүй байна. Ийнхүү нийт эвлэрүүлэн зуучлалаар явуулсан хэргийн 88 хувь нь эвлэрдэггүй буюу шүүхээр цуцлуулж байгааг анхаарах шаардлага үүсчээ.
- Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас яаралтай гэр бүл цуцлуулах тохиолдолд нотлохыг шаардах нь бодит байдал дээр гэр бүлийн хүчирхийлэлтэй ч тогтоож чадаагүй үед хугацаа алдаж, нотлох баримт шаардаж, эвлэрүүлэх гэж оролдсоноор цуцлуулах нэхэмжлэл гаргасан гэрлэгч хохирох, даамжрах, амь нас, эрүүл мэндээрээ улам хохирох нөхцөд байдлыг гааруулахаар байна. Харин ийм шалтгаантайгаар цуцлуулах нэхэмжлэлийн үед шүүхээс нотлох үүргийг мөн хүлээж шалгах ажиллагаа явуулдаг байх зэргээр аль болох нотлогдоогүй бол заавал эвлэр гэж цуцлуулахыг нь хойшлуулдаг байдлыг засах шаардлагатай байна.
- Мөн гэрлэлт цуцлуулах үндэслэлийг хуульд зааж өгч нэг тал нь зөвшөөрөөгүй, нөгөө тал нь цуцлуулах нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд эдгээр үндэслэлийг бүрдсэн эсэхийг тогтоож, цуцлах, хэрэв бүрдээгүй бол цуцлахгүй байхаар заах шаардлагатай байна.
- Өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэргийг нээлттэй шүүх хурлаар хийх боломжтой байгаа нь хүүхдийн эмзэг байдлыг илчлэх, сөрөг үр дагавар гарахаар байна.
- Мөн өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэрэг, эсхүл хүүхэд хохирогч болсон, гэр бүлийн хүчирхийллийн хэргийг давхар гэр бүл, хүүхдийн шүүх шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Гэр бүл, хүүхдийн шүүх байгуулагдсантай холбогдуулан гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хууль тогтоомжийг сайжруулахад дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Гэр бүлийн хэрэг маргаанд талуудын диспозитив зарчим үйлчлэхээс гадна шүүх нотлох, мөрдөн шалгах зарчим хэрэгжихийг хуульчлах, шүүх нөхцөл байдлыг шалгах, баримт цуглуулах идэвхтэй ажиллагааг хуульчлах, энэ нь эвлэрүүлэн зуучлагчид мөн хамааралтай байх
- Мөн гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эрхийг хуульчлах
- Эвлэрүүлэн зуучлал гэдэг бол бодитоор албадан эвлэрч цуцлуулахгүй байхад чиглэсэн зүйл биш гэрлэлт цуцлуулах тохиролцоогоо эвээр хийж, хүүхэд асрах, тэжээн тэтгэх асуудлыг эвээр шийдвэрлэх тухай асуудал болохыг анхаарах. Ингэвэл шүүхээр заавал ахиж оролгүй гэрлэлт цуцлуулах тохиролцоогоо эвийн журмаар хийх нөхцөл бүрдэнэ.
- Үнэхээр эвлэрэх боломжгүй, тусдаа амьдардаг, өөр хүнээс хүүхэдтэй болсон, гэр бүлийн хүчирхийлэл байж болзошгүй зэрэгт эвлэрэх ажиллагаа заавал хийхгүй байхаар хуульчлах

- Гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шийдэхдээ бусад дагалдах асуудлууд үүний дотор хүүхдийн асуудлыг заавал, яаралтай шийддэг болгох
- Өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэргийг нээлттэй шүүх хурлаар хийх боломжтой байгаа нь хүүхдийн эмзэг байдлыг илчлэх, сөрөг үр дагавар гарахаар байгааг, бусад улсын сайн туршлагыг харгалзан хаалттай байдлаар шийдвэрлэдэг болгох
- Мөн өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэрэг, эсхүл хүүхэд хохирогч болсон, гэр бүлийн хүчирхийллийн хэргийг давхар гэр бүл, хүүхдийн шүүх шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй байгааг нягтлах буюу бусад улсын хувьд хүүхдийн үйлдсэн хэрэгт зориулсан тусгай процесс байгааг анхаарч, хүүхэд хохирогч болсон тохиолдол, гэр бүлийн хүчирхийллийн хэргийн үйлдэгч нь насанд хүрсэн хүн тул ердийн процесс хэрэглэгдэхийг анхаарах шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖ

Шүүх байгуулах тухай хууль

Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Гэр бүлийн тухай хууль

Улсын дээд шүүхийн 2010 оны ИХШХШ ажиллагаан дахь зохигчдыг эвлэрүүлэх шүүгчийн ажиллагааны тухай 02 зөвлөмж

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоол

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ

Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг ТББ, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, 2020.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть, 2022 он, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ.

Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, №4.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас 2024.11 сар.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны албан бичгээр ирүүлсэн статистик тоо мэдээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс албан бичгээр ирүүлсэн шүүхийн статистик мэдээ 2018-2023 он.

Shuukh.mn

БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэх тухай хууль
https://elaw.klri.re.kr/eng_service/lawViewContent.do?hseq=18173

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249995&efYd=20231019#0000>

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011헌마232 결정.

Японы Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.

ХБНГУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.

Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хууль

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хууль

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>